



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/531

Арвайхээр

А.Энхцэцэг, Ц.Хишигцогзол, Н.Оюунчимэг нарт
буцалтгүй тусламж олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1.3, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 7 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох" журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хөгжимт драмын театрт хөгжимчнөөр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах болсон тул А.Энхцэцэгт 27,987,926 (Хорин долоон сая есөн зуун наян долоон мянга есөн зуун хорин зургаа) төгрөг, мөн байгууллагад дуучнаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах болсон Ц.Хишигцогзолд 23,323,272 (Хорин гурван сая гурван зуун хорин гурван мянга хоёр зуун далан хоёр) төгрөг, мөн байгууллагад дуучнаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах болсон Н.Оюунчимэгт 24,100,714 (Хорин дөрвөн сая нэг зуун мянга долоон зуун арван дөрөв) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгосугай.

2.Дээрх буцалтгүй тусламжийн нийт 75,411,912 (Далан таван сая дөрвөн зуун арван нэгэн мянга есөн зуун арван хоёр) төгрөгийг орон нутгийн төсвийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101120